

ГАМШГИЙН ҮЕИЙН ХҮН АМД ШААРДЛАГАТАЙ ХҮНСНИЙ НӨӨЦИЙГ ТООЦООЛОХ НЬ

/Хөвсгөл аймгийн Мөрөн суманд тулгуурлан тооцооллыг гаргав /

ДХИС-ийн магистрант, ахлах дэслэгч А.Баянхангай

Хураангуй : Томоохон хэмжээний хохирол, сүйрэл учруулсан гамшиг тохиолдсон үед Хөвсгөл аймгийн Мөрөн сумын хүн амд шаардагдах хүнсний нөөцийг хүн амын судалгаан дээр тулгуурлан ямар хэмжээнд шаардагдах, байгаа нөөц хүрэлцэх эсэхийг тодорхойлох, хариу арга хэмжээг төлөвлөхөд чиглэгдэнэ.

Түлхүүр үг: Гамшгийн үеийн хүнсний нөөцийн тооцоо,

Оршил: Манай орны суурин газрын 75 орчим хувь нь газар хөдлөлтийн 7.0 болон түүнээс дээш, 12 суурин газар 9.0 болон түүнээс дээш баллын газар хөдлөлтийн эрсдэлтэй бүсэд байдаг бөгөөд тэр дундаа Монгол улсын хамгийн олон хүн амтай аймаг болох Хөвсгөл аймагт сүүлийн 3 жил газар хөдлөлтийн тоо, давтамж ихсэж байгаатай холбогдуулан аймгийн нийт хүн амын 35 орчим хувь Мөрөн суманд амьдардаг.

Шинжлэх ухааны академийн Одон орон геофизикийн хүрээлэнгийн судлаачдын гаргасан статистик судалгаанаас үзэхэд 2021 оны 1 сарын 1-нээс тус оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд Монгол орны нутаг дэвсгэрт 137849 удаагийн газар хөдлөлт болсоноос 3,5 магнитуд болон түүнээс дээш хүчтэй газар хөдлөлт 271 удаа болсон 226 удаагийн газар хөдлөлт нь Хөвсгөл аймгийн Мөрөн сумын нутаг дэвсгэрээс 280 км-ийн зайд алслагдсан Ханх суманд болсон байна.⁴¹ Томоохон хэмжээний аливаа гамшиг, аюул тохиолдсон үед Хөвсгөл аймгийн Мөрөн сумын иргэдэд шаардагдах хүнсний нөөцийг хүн амын судалгаан дээр тулгуурлан ямар хэмжээнд шаардагдахыг олоход чиглэгдэнэ.

Тайван цагт Хөвсгөл аймгийн Мөрөн сумын хүн амд шаардлагатай хүнсний нөөц бүрдүүлэлтийг “Гамшгийн үеийн орон нутгийн хүнсний нөөц тооцох аргачлал”-аар тооцож урьдчилан бүрдүүлсэн тохиолдолд гамшгийн үед түүний хор уршгийг арилгах явцад нэрвэгдэгсэд болон бусад хүн амын хүнсний хангалтыг зохион байгуулахад ямар нэгэн бэрхшээл хүндрэл гарахгүй байх нөхцөл бүрдэж өгнө.

Иймд энэхүү хүнсний нөөцийг тооцох аргачлалаар нөөц бүрдүүлэлтийг хийх нь зайлшгүй шаардлагатай үйл ажиллагаа юм.

Судалгааны материалын арга зүй: Харьцуулалт, дүн шинжилгээ хийх аргуудыг ашиглаж хийх.

Үндсэн хэсэг:

Нэг. Гамшгийн үеийн Хөвсгөл аймгийн Мөрөн сумын иргэдийн хүнсний нөөц бүрдүүлэлт

“улсын нөөц” гэж нийгэм, эдийн засгийг тогтвортой байлгах, үндэсний аюулгүй байдал, хүн амыг хангахад зориулагдах болон гамшиг, эдийн засгийн хүндрэл бэрхшээл, дайны байдал зэрэг онцгой байдлын үед энэ хуульд заасан зориулалт, нөхцөлийн дагуу ашиглахаар нөөцлөн хадгалж буй бараа, материалыг /цаашид “нөөцийн бараа, материал”

⁴¹ ШУА-ийн Одон орон геофизикийн хүрээлэн

гэх/;⁴²

“стратегийн нөөц” гэж нийгэм, эдийн засгийг тогтвортой байлгах, үндэсний аюулгүй байдал, хүн амыг хангахад зориулагдах нэр төрөл, тоо хэмжээг нь бууруулж үл болох нөөцийн бараа, материалыг;

“гамшгийн нөөц” гэж гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд зарцуулахаар хадгалсан бараа, материалыг; хэлнэ⁴³ хэмээн заажээ.

Монгол Улсын “Хүнсний тухай хууль”-д заасны дагуу Монгол хүний бие махбодийн хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг хангах, илч зарцуулалтыг нөхөхөд шаардагдах хүнс, үндсэн шимт бодис, эрдэс, аминдэмийн зохистой хэмжээг батлах үүргийг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлэх ёстой байдаг.

Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/74 тоот тушаалаар баталсан “Жишсэн дундаж хүний илчлэгийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ” болон Үндэсний статистикийн хорооны даргын 2008 оны 01/176 тоот тушаалаар баталсан “Хүнсний аюулгүй байдал, хангамжийн статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”-ыг үндэслэж тайван цагийн болон гамшгийн үеийн жишсэн дундаж хүн амын хүнсний хэрэгцээг тооцох аргачлалыг боловсруулсан байна.

Тус аргачлалд жишсэн дундаж хүн амын тайван цагийн жилийн хүнсний хэрэгцээ болон гамшгийн үеийн 3 хоногийн (олон улсад тогтсон жишгийн дагуу) хүнсний хэрэгцээг жишсэн дундаж хүнд шилжүүлэх илтгэлцүүр, жишсэн бүтээгдэхүүнд шилжүүлэх илтгэлцүүр ашиглан тооцдог.

ЖИШСЭН ДУНДАЖ ХҮН АМЫН ТООЦОО

Хүн амын хүнсний жилийн хэрэгцээг тооцохдоо юун түрүүнд жишсэн хүн амын тоог тодорхойлно.

Жишсэн дундаж хүн ам гэж насны бүлэг тус бүрийн хүний тоог шилжүүлэх илтгэлцүүр ашиглан ижил түвшний дундаж хүнд шилжүүлэх илтгэлцүүрийн насны ангиллын дагуу бүлэглэж, илтгэлцүүрээр (хүснэгт №1)-ээр үржүүлэн, бүлэг тус бүрийн дүнг нэмж тооцно. Жишсэн хүн амын тоог дараах томъёог ашиглан тооцно. Үүнд:

$$ХА_{жиш} = \sum K_a \cdot ХА_a$$

ХА_{жиш}-тухайн жилийн жишсэн хүн амын тоо

К_a-а насны бүлгийн хүн амыг жишсэн хүнд шилжүүлэх илтгэлцүүр

ХА_a-а насны бүлгийн хүн амын тоо

Хүснэгт 1

№	Насны бүлэг	Жишсэн хүнд шилжүүлэх илтгэлцүүр	Тухайн жилийн хүн амын тоо	Жишсэн хүн амын тоо
1	0-3 насны	0.52	3650	1,898
2	4-7 насны	0.65	3766	2,447.9
3	8-10 насны	0.73	3074	2,244.02
4	11-14 насны	0.92	2459	2,262.28
5	15-17 насны	1.07	1921	2,055.47

⁴² Улсын нөөцийн тухай хуулийн заалт

⁴³ Улсын нөөцийн тухай хууль

6	18-59 насны	1.27	23419	29.742.13
7	Тэтгэврийн насны	0.96	4796	4.604.16
Дүн				45252

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын нь **хамгийн сүүлийн үеийн буюу 2023 оны статистик мэдээллээр 43085⁴⁴ хүн амтай** байх бөгөөд жишсэн дундаж хүнд шилжүүлэх илтгэлцүүрийн насны ангиллыг статистик мэдээллийн нэгдсэн сангийн насны ангиллын дагуу авлаа.

Хүснэгт 2

№	Насны бүлэг	Жишсэн хүнд шилжүүлэх илтгэлцүүр
1	0-3 насны	$3650 \times 0.52 = 1,898$
2	4-7 насны	$3766 \times 0.65 = 2,447.9$
3	8-10 насны	$3074 \times 0.73 = 2,244.02$
4	11-14 насны	$2459 \times 0.92 = 2,262.28$
5	15-17 насны	$1921 \times 1.07 = 2,055.47$
6	18-59 насны	$23419 \times 1.27 = 29,742.13$
7	Тэтгэврийн насны	$4796 \times 0.96 = 4,604.16$
Дүн	жишсэн хүн амын тоо	45252

ГАМШГИЙН ҮЕИЙН ХҮН АМЫН ХҮНСНИЙ ХЭРЭГЦЭЭГ ТООЦОХ НЬ

Нийт хүн ам, өрх гэр бүл, хувь хүн амьдралынхаа туршид зохистой хүнсээр тогтвортой хангагдаж байх нөхцлийг хүнсний тогтвортой байдал гэх бөгөөд гэнэтийн гамшиг, эсвэл улирлын чанартай хомсдол тохиолдсон үед ч хүнсний хүртээмж тогтвортой байх ёстой. Энэ үүднээс аливаа суурин газрын буюу хот, аймгийн төвийн хүн амын гамшгийн үед хэрэглэх хүнсийг зөв сонгож, хадгалах үүргийг тухайн суурин газрын удирдлагууд хүлээх ёстой.⁴⁵

Энэхүү аргачлалд гамшгийн үед хүн амд нэн зайлшгүй шаардагдах хүнсний бүтээгдэхүүнээр “Стратегийн нөөцийн бараа, материалын нэр төрөл батлах тухай” УИХ-ын 2008 оны 5 дугаар сарын 09 өдрийн 30 дугаар тогтоолоор стратегийн бүтээгдэхүүнд оруулахаар заасан гурил, төрөл бүрийн будаа, элсэн чихэр, цэвэр ус, нөөшилсөн махнаас гадна олон улсын жишгийн дагуу хуурай сүү, давс, ургамлын тос зэрэг бүтээгдэхүүнийг сонгон зөвлөмж болгосон байдаг.⁴⁶

Гамшгийн үед хэрэглэх хүнсний бүтээгдэхүүн нь урт хугацаанд хадгалах боломжтой байх ёстой. Гамшгийн үед нэг хүний хоногт хүнсээс авах шим тэжээлийн хэмжээг олон улсын жишгийн дагуу 2100 ккал-иор тооцож мах, махан бүтээгдэхүүнийг орлох нөөшилсөн мах, сүү, сүүн бүтээгдэхүүнийг орлохуйц хуурай сүү, гурилан бүтээгдэхүүнийг орлохуйц гоймон зэргийг сонгодог. Эдгээр нөөшилсөн, хатаамал хэлбэртэй бүтээгдэхүүний хэрэгцээг тооцохдоо ҮХАА-н сайдын 2013 оны А/162 дугаар тушаал (Хавсралт)-аар баталсан гол

⁴⁴ Хөвсгөл аймгийн статистик мэдээ 2023 оны 03 сарын

⁴⁵ Улсын нөөцийн тухай хууль

⁴⁶ Стратегийн нөөцийн бараа, материалын нэр төрөл батлах тухай” УИХ-ын 2008 оны 5 дугаар сарын 09 өдрийн 30 дугаар тогтоол

нэрийн хүнсний бүтээгдэхүүнийг нэгж бүтээгдэхүүнд шилжүүлэн тооцох илтгэлцүүрийг ашиглана.⁴⁷

Гамшгийн үеийн жишсэн дундаж нэг хүний хоногийн хэрэгцээг тайван цагийн жишсэн дундаж нэг хүний хүнсний хоногийн хэрэгцээг хүнсний бүтээгдэхүүнийг нэгж бүтээгдэхүүнд шилжүүлэн тооцох илтгэлцүүрт хувааж тооцоно. Үүнийг томъёогоор харуулбал:

$$1. \text{ЖДХХI}_{\text{гамшгийн үеийн}} = \frac{\text{ЖДХХ}_{\text{тайван цагийн}}}{\text{ШТИ}}$$

2. $\text{ЖДХХI}_{\text{гамшгийн үеийн}} - \text{Гамшгийн үеийн жишсэн дундаж нэг хүний хоногийн хэрэгцээ}$

3. $\text{ЖДХХ}_{\text{тайван цагийн}} - \text{Тайван цагийн жишсэн дундаж нэг хүний хоногийн хэрэгцээ}$

4. ШТИ – Хүнсний бүтээгдэхүүнийг нэгж бүтээгдэхүүнд шилжүүлэн тооцох итгэлцүүр
Тухайлбал, гамшгийн үед хэрэглэх хүнсний төрлөөр сонгосон нөөшилсөн махыг нэгж бүтээгдэхүүнд буюу маханд шилжүүлэх итгэлцүүр 1,21 бол хуурай сүүг нэгж бүтээгдэхүүнд буюу шингэн сүүнд шилжүүлэх итгэлцүүр 8,60 байна.

Тайван цагт жишсэн нэг хүнд хоногт 200 гр мах, махан бүтээгдэхүүн хэрэглэхийг зөвлөмж болгодог бөгөөд үүнийг нөөшилсөн маханд шилжүүлэн тооцвол:

$$\underline{200 \text{ гр мах, махан бүтээгдэхүүн}} = 165,3 \text{ гр нөөшилсөн мах } 1,21$$

Гамшгийн үед хэрэглэх хүнсний зүйлийг итгэлцүүрт шилжүүлэн тооцсон тооцоо.⁴⁸

Хүснэгт 3

№	Хүнсний төрөл	Гамшгийн үед хэрэглэх хүнсний төрөл	ЖД нэг хүний хоногийн хэрэгцээ, гр	Шилжүүлэн тооцох итгэлцүүр	Гамшгийн үеийн ЖД нэг хүний хоногийн хэрэгцээ, гр
1	Мах, махан бүтээгдэхүүн	Нөөшилсөн мах	200,0	1.21	7.4
2	Сүү	Хуурай сүү	150.0	8.60	17.4
3	Гурил	Гурил	100.0	1.00	100.0
4	Гурилан бүтээгдэхүүн	Гоймон	220.0	1.00	220.0
5	Төрөл бүрийн будаа	Будаа	78.0	1.00	78.0
6	Саахар, чихрийн зүйл	Саахар	23.0	1.00	23.0
7	Ургамлын тос	Ургамлын тос	25.0	1.00	25.0
8	Давс	Давс	5.0	1.00	5.0
9	Ундны ус	Ундны ус	2,000.0	1.00	2,000.0

Дээрх хүснэгтэд заасан итгэлцүүрийг ашиглан жишсэн дундаж хүн амын гамшгийн үед буюу 3 хоногт хэрэглэх хүнсний хэрэгцээг тооцохдоо жишсэн дундаж нэг хүний хоногийн хүнсний хэрэгцээг жишсэн хүн амын тоонд үржүүлэн дахин 3-т үржүүлнэ.

Жишсэн хүн амын гамшгийн үеийн буюу 3 хоногийн хүнсний хэрэгцээг дараах томъёогоор тодорхойлно.

⁴⁷ ҮХАА-н сайдын 2013 оны А/162 дугаар тушаал (Хавсралт)-аар баталсан гол нэрийн хүнсний бүтээгдэхүүнийг нэгж бүтээгдэхүүнд шилжүүлэн тооцох илтгэлцүүр

⁴⁸ ҮХАА-н сайдын 2013 оны А/162 тоот тушаал

$ЖДХХЗ_{гү} = ЖДХХ1_{гү} * ХА_{жиш} * 3 \text{ хоног}$

$ЖДХХЗ_{гү}$ – жишсэн дундаж нэг хүний 3 хоногийн хүнсний хэрэгцээ

$ЖДХХ1_{гү}$ – жишсэн дундаж нэг хүний хоногийн хэрэгцээ

$ХА_{жиш}$ – тухайн жилийн жишсэн хүн амын тоо

Үүнээс улбаалан Хөвсгөл аймгийн Мөрөн сумын хүн амын гамшгийн үед хэрэглэх хүнсний хэрэгцээг тооцоход жишсэн дундаж нэг хүн хоногт 165,3 гр нөөшилсөн махны хэрэгцээтэй гэж үзэж Мөрөн сумын жишсэн хүн амд үржүүлэн үүнийг 3 хоногт үржүүлэн гр-ыг тн-д шилжүүлэх 1000000-д хуваахад 173,8 тн нөөшилсөн мах шаардлагатай байна.

$$\frac{165,3 \text{ гр} * 45252 * 3 \text{ хоног}}{1000000} = 22,4 \text{ тн}$$

Энэ мэтчилэн бусад хүнсний бүтээгдэхүүнийг тооцон хүснэгт 4-т үзүүлэв.

Хүснэгт 4

№	Хүнсний төрөл	Гамшгийн үед хэрэглэх хүнсний төрөл	Гамшгийн үеийн ЖД нэг хүний хоногийн хэрэгцээ, гр	Мөрөн сумын жишсэн хүн амын тоо		Шаардлагатай бараа материалын тоо хэмжээ, тн
1	Мах, махан бүтээгдэхүүн	Нөөшилсөн мах	165.3	45252	3 х о н о г	22,4
2	Сүү	Хуурай сүү	17.4			2,3
3	Гурил	Гурил	100.0			13.5
4	Гурилан бүтээгдэхүүн	Гоймон	220.0			29,8
5	Төрөл бүрийн будаа	Будаа	78.0			10,5
6	Саахар, чихрийн зүйл	Саахар	23.0			3,1
7	Ургамлын тос	Ургамлын тос	25.0			3,3
8	Давс	Давс	5.0			678
9	Ундны ус	Ундны ус	2,000.0			271,5

Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/74 дүгээр тушаалын дагуу тооцсон энэхүү жишсэн нэг хүний нэг хоногийн хүнсээс авах илчлэг, шим тэжээлийг 2500 ккал байхаар тооцсон байдаг бол гамшгийн үед хүнсээс авах илчлэгийн хэмжээг 2100 ккал байхад тохиромжтой гэж олон улсад үздэг байна. Энэ нь тайван цагийн хоногийн хүнсээс авах илчлэгийн 87%-тай тэнцэх хэмжээ юм.

Жишсэн дундаж нэг хүний гамшгийн үед хэрэглэх хоногийн хүнсээс авах илчлэгийн хэмжээ

Хүснэгт 5

№		Жишсэн 1 хүний хоол хүнснээс	Шимт бодисууд, (гр)
---	--	------------------------------	---------------------

	Хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл	хоногт авах илчлэг, ккал*	Уураг	Тос	Нүүрс ус
1	Нөөшилсөн мах	364	34.7	24.8	0
2	Хуурай сүү	87	4.4	4.7	
3	Гурил	350	11.5	1.5	70
4	Гоймон	7	2.4	4.0	
5	Цагаан будаа	284	5.5	0.4	57
6	Саахар	92	0.0	0.0	23
7	Ургамлын тос	221	0.0	25.0	0
8	Ундны ус				
	Бүгд	2163	82,4	60,3	

Дүгнэлт: Энэхүү судалгааны ажлыг дүгнэж үзэхэд Мөрөн сум 45252 хүн амд гамшгийн үед ашиглах нөөц бүрдүүлэлтийг \Хүснэгт 6\ харууллаа.

Хүснэгт 6

д\ д	Хүнсний төрөл	Гамшгийн үед хэрэглэх хүнсний төрөл	Шаардлагатай хүнсний нөөц , тн
1	Мах, махан Бүтээгдэхүүн	Нөөшилсөн мах	22,4
2	Сүү	Хуурай сүү	2,3
3	Гурил	Гурил	13.5
4	Гурилан бүтээгдэхүүн	Гоймон	29,8
5	Төрөл бүрийн будаа	Будаа	10,5
6	Саахар, чихрийн зүйл	Саахар	3,1
7	Ургамлын тос	Ургамлын тос	3,3
8	Давс	Давс	678
9	Ундны ус	Ундны ус	271,5
Нийт			357,7

Дүгнэлт: Мөрөн суманд үйл ажиллагаа явуулж байгаа 7 махны үйлдвэр, хүнсний бараа, материал зардаг 5 том сүлжээ дэлгүүрт байгаа хүнсний бүтээгдэхүүний тоо, хэмжээг Хөвсгөл аймагт 2023 оны 03 дугаар сарын 10-наас 15-ны хооронд “ Гамшгаас хамгаалах команд штабын сургууль” зохион байгуулсантай холбогдуулж гаргуулсан нөөцийн судалгаан дээр тулгуурлаж шаардлагатай хүнсний нөөцтэй харьцуулж үзэж дүн шинжилгээ хийв.

Мөрөн сумын гамшгийн үед бараа материалаар хангах гэрээ бүхий ААНБайгууллагуудад байгаа нөөцийн тоо, хэмжээ 2023 оны 03 дугаар сарын эхний 10 хоногийн байдлаар ⁴⁹

⁴⁹ Аймгийн Засаг даргын 2023 оны А/08 дугаар захирамжаар гэрээ байгуулсан ААНБайгууллагын нөөцийн судалгаа

д\ д	ААБНэр	Мах /тн/	ААБНэр	Сүү /тн/	Гурил /тн/	Гурилан Бүтээгдэ	Төрөл бүрийн	Саахар, чихрийн зүйл	Ургамл ын тос	Давс /тн/
1	Уудам хангай	-	Оргил ХҮТ	1	5	3	13	18	9	2
2	Дуут улаан	3,3	Тэвхэ н ХҮТ	0,6	9	6	12	13	5	1
3	Лидер хүнс	8	Номи н ХҮТ	1,2	12	7	20	15	12	1
4	Баян Шувуу т	12	Эрхэс ХҮТ	1,8	8	2	6	9	3	1
5	Энгэр мөрөн	-	Нар супер марке т	0,5	3	0,5	3	4	1,5	0,3
6	Мах маркет	10 0								
7	Таван- Эрдэнэ	2								
8	Нөөцө нд байгаа хүнс /тн/	12 5,3		5,1	37	18,5	54	60	28,5	5,3
9	3 хоногт шаардл агатай хүнс /тн/	22, 4		2,3	13,5	29,8	10,5	3,1	3,3	678
1 0	Харьцу улалт	17 хо ног		6 хон ог	8 хоно г	Хүр элцэ хгүй 1 хоно г	15 хоно г	58 хоног	25 хоно г	7 хоног

Дээрх харьцуулалтаас харахад Мөрөн суманд 2023 оны 4,5,6 сард мах, гурил, гурилан бүтээгдэхүүний нөөц 7 хонгоос бага хоногийн нөөцтэй байхаар харагдаж байна. Махны үйлдвэрүүд гадны хөрөнгө оруулттай учир мах, махан бүтээгдэхүүнийг нөөцөлдөггүй, мөн бусад аж ахуй нэгж байгууллагууд гэрээнд заасан нөөцийн бараа бүтээгдэхүүнээс бусад бараа

бүтээгдэхүүнийг худалдан борлуулдаг нь гамшгийн үед хүнсний хомсдол үүсэх эрсдлийг бий болгож болох юм гэсэн таамаглалд хүнсний тооцоо хийсэн судалгаа харуулж байна.

Зөвлөмж: Энэхүү өгүүлэлд ашигласан хүнсний нөөцийг тооцоолох аргачлалыг ашиглан цаашид хот, дүүрэг, аймаг, сум хороодууд өөрийн нутаг дэвсгэрт харьяалагдах хүн амын гамшгийн үед хэрэглэх хүнсний нөөцийн тооцоог гаргаж , үүнийг зохих шатны хүмүүст үүрэг болгох түүнчлэн эрх зүйн баримт бичгүүдэд тусгаж өгөх шаардлагатай байна.

Ашигласан материал

1. Гамшгаас хамгаалах тухай хууль
2. Улсын нөөцийн тухай хууль
3. ХХААЯам, Дэлхийн зөн “Гамшгийн үеийн орон нутгийн хүнсний нөөц тооцох аргачлал”
4. Монгол Улсын Хүнсний Тухай хууль
5. Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/74 тоот тушаалаар баталсан “Жишсэн дундаж хүний илчлэгийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ”
6. Үндэсний статистикийн хорооны даргын 2008 оны 01\176 тоот тушаалар баталсан “Хүнсний аюулгүй байдал, хангамжийн статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”